



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/28

Жаргалтхаан сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.2, Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 04 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үе үеийн төгсөгчдийн дунд зохион байгуулах “Хаан цом – 2026” спортын наадмыг 2026 оны 04 дүгээр сарын 11, 12 болон 04 дүгээр сарын 18,19-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. “Хаан цом – 2026” спортын наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Отгонбаяр – Сумын Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: С.Оюунцэцэг – Ерөнхий боловсролын сургуулийн

захирал

Гишүүд: Л.Цэнгэл- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр)

С.Мөнхдэлгэр – Засаг даргын Тамгын газрын дарга

Н.Түвшинжаргал – Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

Ж.Ариунгэрэл–Соёлын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Э.Эрдэнэхүү – Санхүүгийн албаны дарга

Т.Төгөлдөр – Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Б.Амгаланбаяр – Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш


Б.Батзориг - Ерөнхий боловсролын сургуулийн

биеийн тамирын багш

Б.Батхишиг – Сумын хэсгийн төлөөлөгч

2.

3. “Хаан цом – 2026” спортын наадмын удирдамж, төлөвлөгөө, төсвийг боловсруулан батлуулж, чанартай зохион байгуулахыг ажлын хэсэг (Н.Отгонбаяр)-т даалгасугай.

ДАРГА  С.ГАНБАТ